



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 350

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 170,000,000.00 (нэг зуун далан сая) төгрөгийн балансын үнэ, 4,047,619.04 (дөрвөн сая дөчин долоон мянга зургаан зуун арван есөн төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Үндэсний аудитын газарт балансаас балансад шилжүүлсүгэй

2. Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга Ц.Ганболд, “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



000690

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн  
350 дугаар тогтоолын хавсралт



**"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИАС  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

| Д/д      | Автомашины марк, улсын дугаар, арал         | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Балансын үнэ         | Хуримтлагдсан элэгдэл                                                       | Үлдэх өртөг                                                                                      |
|----------|---------------------------------------------|-----------------------------------|----------------------|-----------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|
|          |                                             |                                   | (төгрөг)             |                                                                             |                                                                                                  |
| 1        | Ниссан патрул, 05-78 УАК, JN8BY2NY3K9215144 | 2019/2020                         | 170,000,000.00       | 4,047,619.04                                                                | 165,952,380.96                                                                                   |
| Нийт дүн |                                             |                                   | 170,000,000.00       | 4,047,619.04                                                                | 165,952,380.96                                                                                   |
|          |                                             |                                   | (нэг зуун далан сая) | (дөрвөн сая дөчин долоон мянга зургаан зуун арван есөн төгрөг дөрвөн мөнгө) | (нэг зуун жаран таван сая есөн зуун тавин хоёр мянга гурван зуун наян төгрөг ерэн зургаан мөнгө) |